



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 91

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хил хамгаалах ерөнхий газрын харьяа хилийн цэргийн 0119 дүгээр ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 12 нэрийн, нийт 51,114,600.00 (тавин нэгэн сая дөрвөн зуун арван дөрвөн мянга зургаан зуу) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Хил хамгаалах ерөнхий газрын дарга бригадын генерал Х.Лхагвасүрэн, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал, дэд хурандаа Х.Бат-Ирээдүй нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн
97 дугаар тогтоолын хавсралт

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ХИЛИЙН ЦӨРГИЙН 0119 ДҮГЭЭР
АНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Ашиглал- тад орсон огноо	тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
				(төгрөг)	
Үндсэн хөрөнгөд бүртгэх					
1	Ширээ (50*50*4.5)	2023.10.1	1	380,000.00	380,000.00
2	Диван кресло	2023.10.1	1	1,299,900.00	1,299,900.00
3	Унтлагын өрөөний буйдан	2023.10.1	1	2,399,900.00	2,399,900.00
4	Сандап	2023.10.1	2	180,000.00	360,000.00
5	Ор	2023.10.1	1	1,199,800.00	1,199,800.00
6	Өвчтөний хяналтын монитор	2023.10.1	6	4,700,000.00	28,200,000.00
7	Дуслын автомат шахуурга	2023.10.1	3	2,500,000.00	7,500,000.00
8	Тарианы автомат шахуурга	2023.10.1	3	2,500,000.00	7,500,000.00
9	Мөлхөө ширээ	2023.10.1	1	790,000.00	790,000.00
10	Ширээ сэт	2023.10.1	1	616,000.00	616,000.00
Эргэлтийн хөрөнгөд бүртгэх					
11	Хуйлдаг хөшиг	2023.10.1	25.7	34,980.54	899,000.00
12	Лого	2023.10.1	6	45,000.00	270,000.00
Нийт дүн					51,414,600.00
				(тавин нэгэн сая дөрвөн зуун арван дөрвөн мянга зургаан зуу)	